УЛСЫН ИХ ХУРЛЫН 2012 ОНД БАТЛАГДСАН “АЖИЛЛАСАН ЖИЛ, ТЭТГЭВРИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ НӨХӨН ТООЦОХ ТУХАЙ” ХУУЛИЙН ЗААЛТАД ХАМРАГДААГҮЙ ХУВИАРАА ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧ ИРГЭДИЙГ НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛЭЭ САЙН ДУРААР НӨХӨН ТӨЛСНӨӨР, ТЭТГЭВЭР ТОГТООЛГОХ ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ БИЙ БОЛГОХ АСУУДАЛ

/Мэдээлэл, лавлагаа/

П.Нарантуяа

ОРШИЛ

Улсын Их Хурлын гишүүн Ө.Уянга 2013 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 11/1682 тоот албан бичгээр ирүүлсэн захиалгадаа Улсын Их Хурлын 2012 онд батлан гаргасан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн заалтад хамрагдаагүй хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг нийгмийн даатгалын шимтгэлээ сайн дураар нөхөн төлснөөр, тэтгэвэр тогтоолгох эрх зүйн орчныг бий болгох асуудал, энэ хуульд хамрагдах иргэдийн тоо, төсөвт оруулах боломжтой орлого, учирч болох эрсдэлийн талаар судалгаа хийлгэхийг хүссэний дагуу уг асуудлыг судлан холбогдох мэдээллэл лавлагааг хүргүүлж байна.

Судалгаааны зорилго нь: Монгол Улсын хууль, хуультай холбогдон гарсан журамд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд сайн дурын даатгалын тухай, сайн дурын даатгалд хамрагдаагүй иргэнийг нийгмийн даатгалын шимтгэлээ нөхөн төлж нийгмийн даатгалд хамрагдах боломж байгаа эсэх, боломжгүй бол эрх зүйн орчныг бий болгох асуудал арга замын талаар лавлагаа бэлтгэн мэдээлэл өгөхөд оршино.

Өнөөдрийн байдлаар “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль”-ийн 3.1.8-д “Хувиараа хөдөлмөр эрхлэгч гэж дангаараа болон бусадтай хамтран аж ахуй эрхэлж, татварын албанд бүртгүүлэн бизнесийнхээ үйл ажиллагаанд нөлөөлөх шийдвэрээ хараат бусаар гаргадаг **иргэнийг**” гэж заасан байдаг.[142]

2010 оны статистикийн дүнгээр 175.4 мянган иргэн хувиараа хөдөлмөр эрхэлж байна.[143]

Ажилгүй, цомхтголд өртсөн, үйлдвэр болон албан газрууд нь татан буугдсан, улирлын чанартай ажил эрхэлдэг ажиллах хүчинд зах зээлийн хүнд үед хувиараа хөдөлмөр эрхлэхээс өөрөөр ажиллаж амьдрах боломж гараагүй юм.

Гэхдээ албан бус хөдөлмөр гэдгээр одоог хүртэл томьёологдсоор байгаа хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа нь ажилгүй хүмүүст ажлын байрыг олноор бий болгож, зах зээлийн шилжилтийн хүнд үед чухал үүрэг гүйцэтгэсэн, одоо ч гүйцэтгэсээр байна. Хувиараа хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаа эхэн үедээ ганзгын наймаагаар эхэлж байв.

1993-1996 онд нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн багц хуулиуд батлагдан гарч хөдөлмөрийн харилцаанаас уламжилж үүсдэг байсан ойлголт өөрчлөгдсөнтэй холбоотой Нийгмийн хамгаалалд: Хөдөлмөр эрхэлдэг болон эрхлээгүй байгаа, эрхлэх боломжгүй иргэдийг хамруулах үүднээс **заавал болон сайн дурын** гэсэн даатгалын хэлбэрийг тогтоож, тусламж шаардлагатай байгаа иргэдэд тодорхойшалгуураар туслалцаа үзүүлэх болсон.

[142] Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011.06.17.
[143] Хөдөлмөрийн яам - 2010 оны тайлан. www.mol.gov.mn

Хувираа хөдөлмөр эрхлэгч иргэд "Нийгмийн даатгалын хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2010 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 75/38 Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар нийгмийн даатгалын байгууллагатай даатгалын гэрээ байгуулж орлогоо өөрөө тодорхойлон, сайн дурын даатгалд хамрагдан шимтгэлээ төлснөөр тэтгэвэр, тэтгэмжинд хамрагдах эрх нь нээгдэхийг зохицуулжээ. */Шимтгэл тооцох сарын орлогын доод хэмжээ тухайн үед мөрдөгдсөн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй, дээд хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна./*

Мөн Хувираа хөдөлмөр эрхлэх замаар үйлдвэрлэл, ажил үйлчилгээ эрхэлж байгаа иргэд "Нийгмийн даатгалын хууль"-ийн 4 дүгээр зүйлийн 3-д Нийгмийн даатгалд даатгуулах эсэх, түүний ямар төрлийг сонгохыг хуульчилсан. Сайн дураар даатгуулагч нь нийгмийн даатгалын дараах төрөл тус бүрд хамрагдаж болно.

Хүснэгт 1.

Нийгмийн даатгалын төрөл	*Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/*	*Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/*
Тэтгэврийн даатгал	7.0	10.0
Тэтгэмжийн даатгал	0.8	1.0
Ажилгүйдлийн даатгал	0.2	1.0
Шимтгэлийн дүн	10.0	12.0

Иргэд сайн дурын даатгалд хэрхэн хамрагдаж байгааг үзүүлвэл:

Хүснэгт 2. **Нийгмийн Даатгалд хамрагдсан сайн дурын даатгуулагчидын мэдээлэл**[144]

	Сайн дурын даатгуулагчид тоо /мян. хүн/	*Төлсөн шимтгэлийн дүн /сая. төг/*
2001	22.5	885.2
2002	22.3	1.070.0
2003	25.6	820.5
2004	29.2	1.126.1
2005	29.0	1.435.7
2006	26.3	1.988.9
2007	51.1	3.910.8
2008	62.6	7.217.2
2009	51.7	9.416.6
2010	63.7	8.257.8
2011	81.6	12.699.4
2012	101.3	17.072.2

Хүснэгт 3. **Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого /сая төгрөг/**

Үзүүлэлт	*2004 он*	*2005 он*	*2006 он*	*2007 он*	*2008 он*	*2010 он*	*2011 он*	*2012 он*
Орлого	115.3	132.1	169.4	225.0	280.0	8.257.8	12699.4	17072.2

[144]Нийгмийн Даатгалын Ерөнхий газрын тайлан - 2010, 2011.

Хүснэгт 4. **Нийгмийн даатгалын сангуудын орлого, зарлага, үлдэгдлийн талаарх мэдээлэл**
/тэрбум, төгрөгөөр/[145]

	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)	Орлого	Зарлага	Зөрүү (+ -)
2004	112. 4	106. 6	5. 8	6. 9	4. 5	2. 3	28. 1	20. 9	7. 2	5. 1	4. 0	1. 0	3. 4	1. 0	2. 3	155. 9	137. 0	18. 6
2005	124. 5	121. 0	3. 5	8. 2	5. 0	3. 1	32. 2	23. 6	8. 5	6. 0	4. 7	1. 2	4. 1	1. 2	2. 8	175. 0	155. 5	19. 1
2006	164. 9	158. 8	6. 1	10. 6	5. 7	4. 8	41. 6	26. 5	15. 1	7. 7	6. 7	1. 0	5. 3	1. 6	3. 7	238. 1	199. 3	30. 7
2007	241. 6	232. 7	8. 8	14. 6	7. 5	7. 0	52. 6	26. 1	26. 4	10. 4	10. 7	-0. 3	7. 2	1. 9	5. 2	326. 4	278. 9	47. 1
2008	336. 6	327. 3	9. 3	12. 8	13. 4	-0. 6	64. 5	50. 8	13. 7	19. 9	14. 5	5. 4	12. 4	3. 2	9. 1	422. 2	409. 2	36. 9
2009	344. 4	333. 0		14. 2	21. 2		72. 4	56. 9		23. 9	23. 6		13. 3	6. 2		471. 4	430. 9	
2010	462. 8			179. 9			91. 3			31. 6			19. 1					
2011	532. 8			251. 1			121. 5			49. 0			27. 0					

Иргэдийн сайн дурын даатгалд хамрагдаж байгаа болон нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого, зарлага 2003-2006 он хүртэл буурах хандлага ажиглагдаж байснаа 2004 оноос нэмэгдээж байгаа нь статистикаас ажиглагдаж байна.

Иргэдээс нийгмийн даатгалын санд ийнхүү сайн дураар хөрөнгө төвлөрүүлж байгаа нь төсөвт ирэх дарамтыг багасгаж байгаа төдийгүй хуримтлагдсан хөрөнгийг эдийн засгийн эргэлтэд зөв оруулж чадвал төсөвт ирэх ачаалал буурах юм. Энэ бол эдийн засагт оруулж байгаа том хөрөнгө оруулалт гэж үзэж болно. Мөн хувиараа хөдлөлмөр эрхлэгчид Төсвийн хуулиар орлогын албан татварыг олон жил төлсөөр ирсэн байна.

Гэхдээ тэтгэврийн даатгалын хуримтлалын тогтолцоо нь улс орнуудад бүрэн хэрэгжиж үр ашиг нь мэдрэгдэгдэж нотлогдоогүй одоогоор Швед, Латви, Литви зэрэг орнуудад манай нэгэн адил нэвтрүүлж эхэлж байгаа шинэ тогтолцоо юм байна.

Улсын Их Хурлын Тамгын газрын судалгааны төвөөс 2010 онд Нийгмийн даатгалын огтолцоо, эрх зүйн орчны талаар судалгаа хийсэн бөгөөд энэ судалгаагаар:

- Та нийгмийн даатгалын үйлчилгээнд хамрагддаг уу гэсэн асуултад 76.3 хувь нь тийм, харин 23.7 хувь нь үгүй гэж хариулжээ.
- Та яагаад нийгмийн даатгалд хамрагдаагүй шалтгаанаа тодорхойлон бичнэ үү гэсэн асуултад дараах байдлаар судалгаанд оролцогчид хариулсан байна. Үүнд:
    1. мэдэхгүйн улмаас - 31.9
    2. бичиг баримт бүрдээгүй - 16.3
    3. шаардлага байхгүй - 14.8
    4. зав чөлөө болж өгөхгүй - 13.3
    5. шилжүүлэг хийгдээгүйгээс - 7.4
    6. бусад шалтгаанаар - 16.3 хувиар тус тус хариулсан байна.

Эндээс иргэдийн нийгмийн даатгалын үйл ажиллагаанд хамрагдахад хамгийн их саад болж буй бэрхшээл нь даатгалын ач холбогдол, үр шимийн талаар мэдлэг мэдээлэл муутай /31. 9 хувь/, холбогдох бичиг баримтаа бүрдүүлж чадаагүй /16. 3хувь/ байдал харагдаж байна. Өнөөгийн нийгмийн даатгал, тэр дундаа тэтгэвэр тэтгэмжийн хэмжээг олон нийт хэрхэн үнэлж байгааг тодруулахаар хийсэн асуулганд тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ боломжийн гэдэгтэй санал нийлэх үү гэсэн асуултад нийгмийн даатгалын тогтолцоо нь санаанд нийцэхгүй гэж оролцогчдын /61. 9 хувь/ үнэлсэн нь дээрхийг баталж байгаа юм.

[145]Үндэсний Статистикийн Хороо, 2004, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010, 2011, 2012.

Хувийн хэвшилд ядуу иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд нэлээд хувийг эзэлдэг ба түрээс төлж ажил эрхэлдэг иргэдэд хөдөлмөрийн хууль үйлчилдэггүй, ажил олгогч эзэд хөдөлмөрийн гэрээ тэр бүр байгуулахгүй зөвхөн аман хэлбэрээр тохирдог, дийлэнх нь бүртгэл тооцоогүй, маркетингийн болон санхүүгийн дэмжлэг муутай, татвараас зугтдаг, хуулийн цоорхойг ашигладаг ажил олгогчид байгаатай холбоотой зэрэг олон хүчин зүйл нөлөөлж хувиараа хөдөлмөр эрхлэгчид сайн дурын даатгалд 100 хувь хамрагдаж чадахгүй байна.

Нэг талаараа иргэдийн хариуцлага, ирээдүйнхээ төлөө хандах хандлага, түүндээ хөрөнгө зарах, үүргээ биелүүлэх, санаа тавихад дутагдал байгаа нь нийгмийн халамж тэтгэвэр тэтгэвэрт хамрагдахад нь муугаар нөлөөлж байгааг үгүйсгэх аргагүй юм.

Гэхдээ Монгол улсад зах зээлийн шилжилтийн үе дуусаагүй, ядуурал мэдэгдэхүйц буураагүй, зохистой ажлын байр, шинэ үйлдвэр аж ахуйн газрууд нэмэгдээгүй, зөвхөн шинээр баригдаж үйл ажиллагаа нь эхэлж байгаа худалдаа үйлчилгээний газруудаар хязгаарлагддаг зэргийг харгалзан хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчдыг Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 5-д заасан нас өндөр болсон үедээ төрийн халамж авах эрхийг нь эдлүүлэхэд төрөөс тодорхой, цогц бодлого явуулах нь цаг хугацаа алдахгүй чухал шийдвэр болох юм.

Учир нь 2010-2040 он хүртэлх хүн ам зүйн бодлого статистик судалгааны явцаас харахад тэтгэврийн насны хүн 2010 онд хүн амын 7 хувийг эзэлж байсан бол 2020 онд 10 хувь, 2040 онд 20 хувь болон өсөж, хүн амын 20 хувь нь 30 жилийн дараа өндөр настан байх урьдчилсан дүн гарсан нь цаашид өндөр настны нийгмийн халамж, үйлчилгээний ачааллыг эртнээс зохицуулах, бодлогын цогц арга хэмжээ авах шаардлагатай нийцнэ.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монголын ажил олгогч эздийн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооноос 2005 онд батлан гаргасан Зохистой хөдөлмөр эрхэлтийг дэмжих үндэсний төлөвлөгөөнд нийгмийн даатгалын тогтолцоог хэрэгжүүлэхээр тусгасан боловч одоог хүртэл хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн тэтгэвэр, тэтгэмжийн асуудлаар **тодорхой хууль гараагүй байна.**

Монгол улсын мянганы зорилтуудын хэрэгжилтийн тайланд “Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид тулгардаг нийтлэг бэрхшээл нь тогтвортой бус орлого, хөдөлмөрийн муу нөхцөл, эрсдэлд өртөмтгий байдал болон нийгмийн даатгалд хамрагдаж чадахгүй байгаа явдал юм. Албан салбарыг өргөжүүлэх хирээр малчид, хувиараа эрхлэгчдийн тоо буурах магадлалтай боловч ойрын хугацаанд өргөн хүрээтэй хэвээр байх төлөвтэй тул тэднийг дэмжин албан салбарт шилжүүлэх нь бодлогын тэргүүлэх чиглэлүүдийн нэг болж байна гэж дурьджээ.

Мөн Монгол улсын эдийн засаг нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд: “**Нийгмийн даатгалын ялангуяа, тэтгэврийн даатгалын тогтолцоог Хүний хөгжил сангийн цаашдын хөгжилтэй уялдуулан шинэчлэх ажлыг 2013 онд судалж шийдвэрлэн холбогдох хууль тогтоомжуудад өөрчлөлт оруулах ялангуяа малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн онцлогт тохирсон тэтгэврийн тогтолцоог бий болгоход шаардлагатай холбогдох хууль”-ийн төслүүдийг эцэслэн боловсруулахаар тусгажээ.**

Улсын Их Хурлын 2012 оны намрын чуулганаар ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль гаргасан нь иргэддээ төрөөс үзүүлж байгаа том дэмжлэг шийдвэр болсон гэж иргэдээс үзэж байгаа юм байна.

Гэхдээ энэ нь Хувираа хөдөлмөр эрхэлж байгаа нийт иргэдийн асуудлыг цогцоор шийдэж чадсан уу гэвэл өрөөсгөл бөгөөд хувираа хөдөлмөрлөгч иргэд 100 хувь сайн дурын даатгалд хамрагдаагүй байгаагаар тодорхойлогдож болно. Сайн дурын даатгалын шимтгэлийг нөхөн төлөхийг хуулиар зөвшөөрөөгүйгээс нийгмийн даатгалын хуулинд хамрагдаж чадахгүй байна.

Дээрх судалгаа лавлагааны явцаас дараах дүгнэлт гаргаж байна. 2001 оноос одоог хүртэл сайн дурын даатгалд хамрагдаж чадаагүй иргэдийн шимтгэлээ нөхөн төлөх боломжийг хуулиар нээлттэй болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байгаа бөгөөд энэ асуудлыг шийдвэрлэснээр төрөөс халамжийн тэтгэвэр авагчдын тоо цөөрч, иргэдийг ядууралд өртөхгүй байнгын орлоготой болсноор ядууралд өртөхгүй нөхцөл бүрдэх юм.

Урьд батлагдсан хуулинд хамрагдаж чадаагүй хувираа хөдөлмөр эрхлэгч иргэдийн 2001 оноос хойш сайн дурын даатгалд хамрагдаж чадаагүйгээс шимтгэлээ нөхөн төлж чадахгүй байгаа байдал журамд орж тэтгэвэр тэтгэмжийнх нь асуудал нэг мөр болон шийдэгдэх боломж нээгдэнэ.

Сайн дурын даатгалаа иргэн дангаараа өөрөө хариуцан төлөх дүнг үзүүлвэл:

Хүснэгт 5. **Шимтгэл тооцох хөдөлмөрийн хөлсний хэмжээ**

	Дээд		***Доод***	
2001	247,500		18,000 24,750	1-9 сар 10-12 сар
2002	247,500		24,750	
2003	300,000		30,000	
2004	300,000 400,000	1-2 сар 3-12 сар	30,000 40,000	1-2 сар 3-12 сар
2005	400,000 425,000	1-6 сар 7-12 сар	40,000 42,500	1-6 сар 7-12 сар
2006	425,000 530,000	1 сар 2-12 сар	42,500 53,000	1 сар 2-12 сар
2007	690,000 800,000 900,000	1-6 сар 7-9 сар 10-12 сар	69,000 80,000 90,000	1-6 сар 7-9 сар 10-12 сар
2008	1,080,000		108,000	
2009				
2010	1,080,000		108,000	
2011	1,080,000 1,404,000	1-3 сар 4-12 сар	108,000 140,400	1-3 сар 4-12 сар
2012	1,404,000		140,400	

Судалгааны явцад хувираа хөдөлмөр эрхлэгчдийн талаарх статистик үзүүлэлт ойлгомжтой тодорхой биш, зарим мэдээллүүд хуучирсан, гаргасан судалгаанууд хоорондоо зөрөөтэй зэрэг байдал гарч байгаа нь мэдээлэл лавлагаа бэлтгэхэд хүндрэлтэй байсныг дурьдаж байна.

Цаашид Хувираа хөдөлмөр эрхлэгч иргэдийн талаарх мэдээллийн санг богино хугацаанд бүрдүүлэн, талуудад үнэн зөв бодитой мэдээлэл өгөх шаардлагаас үндэслэн статистикийн хорооноос улирал, жилээр гаргадаг статистистикийн үзүүлэлтэнд Хувираа хөдөлмөр эрхлэгчдийн талаарх мэдээллийг оруулах, түүвэр судалгааг ойр ойрхон хугацаанд хийж байх нь асуудал шийдвэрлэхэд маш чухал гэж үзлээ.

Хувираа хөдөлмөр эхлэгч иргэдээс богино хугацаанд шимтгэлээ төлөх хөрөнгө хуримтлагдаж чадвал төсөвт ирэх ачаалал бага байх тодийгүй, иргэдэд халамжийн тэтгэвэрийг олгоход зарцуулж байгаа хөрөнгөнөөс хавьгүй илүү үр ашигтай нь харагдаж байна.

Сайн дурааараа даатгалаа төлөхгүй яваад байвал болох юм гэсэн ойлголт иргэдийн дунд төрөхөөс болгоомжлон үүрэг хариуцлагын талаар /алданги, торгууль төлөх гэх мэт/ тодорхой заалтуудыг хуулинд тусгах ингэснээр иргэдийн үүрэг хариуцлага нэмэгдэх болно.

Ажил олгогчийн буруугаас шимтгэл төлөөгүй, удаан хугацаанд ажил олдохгүй, улирлын чанартай болон богино хугацааны ажил эрхэлж байсан, банк санхүүгийн элдэв хямралд өртсөн, ар гэрийн гачигдалтай байсан, өрх толгойлсон гэх мэт хүндэтгэн үзэх шалтгаануудыг харгалзан үзэх нь шинээр хууль гаргахад зайлшгүй анхаарах асуудлуудын нэг гэж үзлээ.
Мөн хувираа хөдөлмөр эрхлэгч иргэд малчдын талаар нийгмийн хамгаалалын талаар тодорхой хууль гаргаж заавал даатгалд хамрагдахаар зохицуулах нь дээрх байдлаас харагдаж байна.

Сайн дурын даатгал нь мөнгөн хөрөнгө бүрдүүлж нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлдэг томоохон хөрөнгө оруулалт болохын хувьд даатгуулагчдыг эдийн засгийн талаар хөхүүлэн дэмжих, урамшуулах, хөнгөлөлтийн хувь эзэмшүүлэх нь өнөөдрийн зах зээлийн нийгэмтэй тохирох шударга зарчим болох юм.

Цаашид шинээр гарсан хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэх, сурталчилахад бүх бололцоотой арга хэмжээнүүдийг цаг алдахгүй шуурхай авч асуудлыг шийдвэрлэх, иргэдэд хүндрэл чирэгдэл учруулахгүй уян хатан хандах, дэмжих туслахад холбогдох яам, газруудтай даатгалын байгууллага хамтран ажиллаж шинэлэг арга хэмжээнүүдийг хэрэглэж байх шаардлагатай нь дээрх лавлагааг бэлтгэх явцад ажиглагдсан юм.

* * *

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Нийгмийн даатгалын хууль, 1994 он.
- Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хууль, Хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам, УБ., 2012 он.
- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, 2011 он.
- Үндэсний статистикийн хороо Монгол Улсын хүн амын 2008-2030 оны хэтийн тооцоо. УБ., 2008 он.
- Нийгмийн даатгалын газрын 2010 оны тайлан.
- Хүн ам хөгжлийн асуудал сэтгүүл. УБ., 2009, 2010, 2011 он.
- Нийгмийн хамгааллын эрхзүй. УБ., 2010 он.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл.
- Монгол Улсын Хүний хөгжлийн илтгэл. УБ., 2007, 2011 он.